

**ЗАХИАЛАГЧ:**  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*S. Баншагай*

БГАНШАГАЙ

ТУЗ1732 5047761

**ГҮЙЦЭТГЭГЧ:**  
“МЕДКЛИЙН”  
ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

*Ц.Гантөмөр*

Ц.ГАНТӨМӨР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, ӨРХИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВД 2023-2024 ОНД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ,  
УРВАЛЖ ОНОШЛУУР ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар: [ӨМАЭМГ/202303001]

Өмнөговь аймаг

### Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

Нэг талаас Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар /цаашид “захиалагч” гэх/, нөгөө талаас “Медклийн” ХХК /цаашид “нийлүүлэгч” гэх/, Өмнөговь аймгийн 14 сумын ЭМТ /цаашид “хэрэглэгч” гэх/, талууд дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ /цаашид “гэрээ” гэх/ байгуулав.

Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, хэрэглэгч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь Өмнөговь аймгийн сум, сум дундын эмнэлэгт эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур нийлүүлэх : [ӨМАЭМГ/202303001]-г (цаашид “бараа” гэх), 12-р багцад **30,888,100.00** (гучин сая найман зуун наян найман мянга нэг зуу) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

- Хэрэглэгч нь барааны нийлүүлэлтийн **30,888,100.00** (гучин сая найман зуун наян найман мянга нэг зуу) төгрөгийг 14 сумын эрүүл мэндийн төв урсгал төсвийн санхүүжилтээс санхүүжүүлнэ.
- Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
- Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.
- Энэхүү гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал үүнээс болж нөгөө талдаа учирсан бүх хохирол түүний дотор өгөх ёстой байсан орлогыг хууль тогтоомжид заасан журмаар төлнө.
- Хэрэв гэрээний хугацаа дуусахаас өмнө өөрийн үргийг биелүүлэхээс үндэслэлгүйгээр нэг талын журмаар татгалзсан буруутай тал нөгөө талдаа гэрээний нийт дүнгийн 3%-ийн торгууль төлнө.

6. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж **2024 оны 04 сарын 01-ний** өдрийг хүртэл үйлчилнэ.
9. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд; Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь
  - a. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
  - b. Бусад шаардлагатай баримт бичиг
  - c. Тендер ба үнийн хуваарь
  - d. Гэрээний тусгай нөхцөл
  - e. Гэрээний ерөнхий нөхцөл
  - f. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь
10. Хэрэв аль нэг тал гэрээг хүчингүй болгох буюу өөрчлөх тухай санаалаа уг гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас өмнө 1 сар хүртэлх хугацаанд гаргаагүй бол энэ гэрээг дуусах хүртэл нь хүчинтэйд тооцно.
11. Энэ гэрээтэй холбогдуулан аль нэг талын гаргасан гомдлыг нөгөө тал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор авч үзэн шийдвэрлэнэ.
12. Хоёр талын тохиролцоонд хүрч чадаагүй маргааныг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
13. Энэхүү гэрээний нөхцөлийг зөвхөн хоёр талын бичгээр үйлдсэн тохиролцооны үндсэн дээр өөрчилнэ.
14. Гэрээний аль ч тал нөгөө талынхаа бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэ гэрээний эрхээ хөндлөнгийн этгээдэд шилжүүлэн өгч болохгүй.
15. Энэхүү гэрээ нь /гэрээний ерөнхий нөхцөл/, /нийлүүлэгч талын эрх, үүрэг, хариуцлага/, /хэрэглэгч талын эрх, үүрэг, хариуцлага/, /захиалагчийн эрх, үүрэг, хариуцлага/, /захиалагч, нийлүүлэгч, хэрэглэгч талуудын баталгаажуулалт/, /нийлүүлэлтийн хуваарийн дагуу хийсэн гэрээний хавсралт/-аас бүрдэнэ. 14 СЭМТ-н улирлын хуваарийг файлаар нийлүүлэгч байгууллагын и-мэйл хаягаар хүргүүлнэ.

#### **Хоёр. Нийлүүлэгч талын эрх, үүрэг, хариуцлага**

1. Нийлүүлэгч нь гэрээний хавсралтад заасан барааг нийлүүлэлтийн хуваарийн дагуу **2023 оны II улиралд нийлүүлэх эм барааг 2023 оны 5 сарын 31 -ний дотор, III улиралд нийлүүлэх эм барааг 2023 оны 8 сарын 01-ний дотор, IV улиралд нийлүүлэх эм барааг 2023 оны 11 сарын 01-ний дотор, 2024 оны I улиралд нийлүүлэх эм барааг 2024 оны 1 сарын 15-ны дотор** захиалагчид хүлээлгэн өгнө.
2. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу хэрэглэгчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
3. Нийлүүлэгч нь тендер шалгаруулалтаар авсан эм, эмнэлгийн хэрэгслийн багцыг гэрээнд хавсаргасан эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах хуваарийн дагуу эцсийн цэгт хүргэн нийлүүлнэ. /Эцсийн цэг: Эрүүл мэндийн газар /
4. Нийлүүлэгч нь эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хангасан найдвартай тээврийн хэрэгсэл, итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр тээврийн зардлыг бүрэн төлж хүргүүлнэ.

5. Нийлүүлэгч нь эм, эмнэлгийн хэрэгслийг ачуулснаас хойш 6 цагийн дотор Эрүүл мэндийн газрын эмийн хангамж хариуцсан мэргэжилтэнд утсаар мэдэгдэнэ. Захиалагч талд утсаар мэдэгдээгүй тохиолдолд нийлүүлэгчийн талд гарсан хохирлыг захиалагч тал хариуцахгүй. (**ЭМГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН Д.СЭЛЭНГЭ УТАС 99729745**)
6. Нийлүүлэгч нь эм, эмнэлгийн хэрэгслийг захиалагч хүлээн авах хүртэлх хугацаанд хөлдөх, гэмтэх, устахаас бүрэн хамгаалж, тээвэрлэлт, хадгалалтын стандарт шаардлага хангах хайрцаг давандаа хийх бөгөөд тээвэрлэх горимыг тусгасан шошго хаягийг Олон улсын стандартын дагуу таних тэмдгээр зурж, бичиж хаягжуулсан байна. (Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт хамгаалалтын горим алдагдуулсан тохиолдолд нийлүүлэгч тал хариуцлага хүлээх болно.)
7. Нийлүүлэгчийн бэлтгэн нийлүүлж буй эм, эмнэлгийн хэрэгсэл нь дараах шаардлагыг бүрэн хангасан байна. Үүнд:
  - a/ Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Техникийн тодорхойлолтод заасан улс болон үйлдвэрлэгчийн эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх
  - б/ Гэрээний хавсралтад заасан тун туншил, тоо хэмжээнд нийцсэн савлагаатай
  - г/ Эм, эмнэлгийн хэрэгсэл нь эцсийн цэгт хүрсэн өдрөөс хойш **1** жилээс дээш хугацаанд ашиглагдах баталгаат хугацаатай байх
8. Бэлтгэн нийлүүлэгч нь хуваарийн дагуу нийлүүлж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн **зарлагын баримтыг 3 хувь, нэхэмжлэхийг 1 хувь** засваргүйгээр бичиж ирүүлнэ. Зарлагын баримтад эм тус бүрийн цувралын дугаар, хүчинтэй хугацааны мэдээллийг бүрэн бичигдсэн байна
9. Бэлтгэн нийлүүлэгч нь өөрийн бэлтгэн нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, баталгаат хугацаа, найдвартай байдлыг гэрээ байгуулсан өдрөөс хойш 1.5 жилийн хугацаанд бүрэн хариуцна. Уг нөхцөлийг зөрчсөн тохиолдолд эм, эмнэлгийн хэрэгслийг бэлтгэн нийлүүлэгчид буцаан солиулах, тасалдсан хугацааны хоног тутамд үнийн дүнгийн 0,1%-ийн алданги тооцно.
10. Эм, эмнэлгийн хэрэгслийн тоо ширхгийг дутуу ирүүлсэн, эмийн чанарт өөрчлөлт орсон тохиолдолд 14 хоногийн дотор захиалагчид хохирлыг барагдуулж, гарсан зардал мөнгийг бүрэн шийдвэрлэн ажиллана.
11. Бэлтгэн нийлүүлэгч нь эм, эмнэлгийн хэрэгслийг огт нийлүүлээгүй буюу гэрээнд заасан иж бүрдэл, тоо хэмжээнээс дутуу нийлүүлсэн, нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн, эм тариаг тасалдуулсан, нийлүүлэлтийн явцад үнэ өртгийг өөрчилсөн зэрэг тохиолдлуудад нийт үнийн дүнгийн 10% бодож алданги тооцно.
12. Импортоор нийлүүлэгдэх боломжгүйгээс тасалдал үүсэх эм, эмнэлгийн хэрэгслийг тухай бүрд нь ЭМГ-н эмийн хангамж хариуцсан мэргэжилтэнд мэдээлж байх.

#### **Гурав. Хэрэглэгч талын эрх, үүрэг, хариуцлага**

1. Хэрэглэгч нь нийлүүлэгч талаас эм, эмнэлгийн хэрэгслийг хугацаанд нь бүрэн нийлүүлж, дагалдаа баримт бичгүүдийг бүрэн ирүүлсэн тохиолдолд **хуваарийн дагуу нийлүүлэгдсэн эм барааны төлбөрийг тухайн улиралд (2023 оны 6-р сарын 30, 2023 оны 9-р сарын 30-ны, 2023 оны 12-р сарын 15-ны, 2024 оны 3-р сарын 30-ны дотор) багтаан бүрэн шилжүүлнэ**. Хэрэглэгч нь нийлүүлэгчийн ханган нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийг гэрээнд

заасан хугацаанд төлөөгүй, өр авлага үүсгэсэн тохиолдолд үнийн дүнгийн 0,1 хувийн алданги тооцож нийлүүлэгчид төлнө.

2. Хэрэглэгч нь захиалагч байгууллагын эдийн засагчид **сар бүрийн 3-ны дотор тендерийн эмийн төлбөр тооцооны талаар тайлан мэдээг өгнө.**
3. Тендерийн гэрээгээр нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой санал хүсэлтийг тухай бүр захиалагчид мэдээлж байх /ЭМГ-ын Эмийн Хангамж Хариуцсан мэргэжилтэн Д.Сэлэнгэ утас: 99729745/
4. Эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах ажлын хэсэг байгуулан эм барааг хүлээн авсан тухай акт үйлдэн ЭМГ-ын эмийн мэргэжилтэнд З хоногийн дотор мэдээлж байх
5. Нийлүүлэгдэж буй эм, эмнэлгийн хэрэгслийг хэрэглэгч тал захиалагчаас акт үйлдэн хүлээн авснаас хойших чанар аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
6. Нийлүүлэгч эм барааг ЭМГ-т нийлүүлснээс хойш захиалагч 24 цагийн дотор хэрэглэгчид мэдэгдэх бөгөөд хэрэглэгч З хоногийн дотор захиалагчаас хүлээн авсан байх

#### **Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг, хариуцлага**

1. Захиалагч талын эм бараа хүлээн авах комисс нь эм, эмнэлгийн хэрэгслийг тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагын дагуу зохих тоо, чанарыг тооцож хүлээн авч сум, сум дундын эмнэлгийн захиалгын дагуу түгээнэ.
2. Захиалагч нь эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрөл, тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд бэлтгэн нийлүүлэх шинэ хугацаа эхлэхээс 15 хоногийн өмнө нийлүүлэгчид хүргэнэ. Хэрэв нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор татгалзаж байгаагаа мэдэгдээгүй бол зөвшөөрсөнд тооцно.
3. Захиалагч нь нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, баталгаат хугацаа, захиалсан тоо хэмжээ, савлагаанд тохирохгүй, шаардлага хангахгүй гэж үзвэл буцаах эрхтэй.
4. Захиалагч нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зарлагын баримт нэхэмжлэлийн хамт хэрэглэгчид хүлээлгэн өгнө.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
ЭМГ-ын Эмийн хангамж хариуцсан  
мэргэжилтэн Д.Сэлэнгэ  
  
[Гарын үсэг] .....  
Эрүүл мэндийн газар  
[Утас/факсын дугаар]  
99729745

#### **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
Медклини ХХК менежер М.Долгорсурэн.  
  
[Гарын үсэг]. *Д.Сэлэнгэ*.....  
ТАМГА  
[Хаяг] БЗД, 3-р хороо, Энэрэл эрүүл мэндийн  
төв, 303-304 тоот  
  
[Утасны дугаар]  
77002120, 96889964, 90052127  
  
[Хариуцагч банкны нэр, дансны дугаар]  
Голомт бан: 1605020366


**ХЭРЭГЛЭГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр, гарын үсэг, тамгаар  
баталгаажуулна]

1. Баяндай СЭМТ-н дарга

 ..... Мягмарцэрэн/


2. Баян-Овбо СЭМТ-н дарга

 ..... /Э.Бямбаахүү/

3. Булган СЭМТ-н дарга

 ..... /Б.Ганбаатар/

4. Түрвантэс СЭМТ-н дарга

 ..... /З.Оюунцэцэг/


**ХЭРЭГЛЭГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр, гарын үсэг, тамгаар  
баталгаажуулна]

5. Мандал-Овоо СЭМТ-н дарга

 ..... А.Мөнхтогоо

6. Манлай СЭМТ-н дарга

 ..... Д.Уламбаяр


7. Ноён СЭМТ-н дарга

 ..... Ц.Сүрэнжаргал

8. Номгон СЭМТ-н дарга

 ..... Х.Мядагмаа

9. Сэврэй СЭМТ-н дарга

 ..... Д.Алтансүх

**ХЭРЭГЛЭГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр, гарын үсэг, тамгаар  
баталгаажуулна]


10. Ханбогд СЭМТ-н дарга

 ..... Б.Тогосмаа


11. Ханхонгор СЭМТ-н дарга

 ..... О.Хүрлээхүү

12. Хүрмэн СЭМТ-н дарга

 ..... Б.Туул

13. Цогт-Овоо СЭМТ-н дарга

 ..... Н.Бямбацэрэн

14. Цогтийн СЭМТ-н дарга

 ..... Б.Амартувшин